ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024.04.03 Улаанбаатар хот

| Д/д | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | | Хариуцах |
|---|---|---|---|---|---|
| | | | Хугацаа | Шалгуур үзүүлэлт | |
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас;<br>б/сошиал сувгууд;<br>в/дотоод сүлжээ;<br>г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл,<br>д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц,<br>е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх. | Тухай бүр | -Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх;<br>-Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрд тайлагнадаг байх;<br>-Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших;<br>-Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших; | Хяналт шалгалт, аюулгүй байдлын газар,<br>Хорих анги,<br>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгж |
| | | 1.2 Иргэд, олон нийтэд чиглэсэн “Та авлигагүй бүсэд нэвтэрлээ” нөлөөллийн соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах. | 2024 он | -ШШГЕГ-ын харьяа анги, байгууллага нь тус бүр 1-ээс доошгүй нээлттэй өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>-Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх;<br>-Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх;<br>-Үр дүнг тооцсон байх.<br>-Анги, байгууллага бүр иргэд, олон нийтэд хүртээмжтэй байдлаар харагдахуйц “Та авлигагүй бүсэд нэвтэрлээ” | Хорих анги,<br>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгж |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | нөлөөллийн постер байршуулах,<br>-Холбогдох хууль тогтоомжтой танилцах боломжийг бүрдүүлэх;<br>-ШШГЕГ-аас хүргүүлж буй мэдээллийг тухай бүрд самбарт байршуулах;<br>-Байршуулсан тухай нотломжийг тайланд хавсаргасан байх; | |
| | | 1.3. Байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном, гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах. | 2024 он | - Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх;<br>- Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх;<br>- Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх;<br>- Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших; | Хэвлэл мэдээллийн төв, Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгж |
| | | 1.4. Иргэний болон эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нарт авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх. | 2024 он | -Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх;<br>- Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх;<br>- Олон нийтэд түгээсэн байх; | Шийдвэр гүйцэтгэх алба, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс |
| 2 | Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх | 2.1. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд томилон оролцуулах шинжээчдэд элдэв нөлөөнд автахгүй байхад чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах. | 2024 он | -Хуульд заасны дагуу олгогдсон эрхтэй байх;<br>-Хуулийн хэрэгжилт хангагдсан байх; | Шийдвэр гүйцэтгэх алба, Аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2.2. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хангах. */Нэг цэгийн үйлчилгээ бүхий төв, цагдан хорих байр /Төв, Зуунмод сум/ 2. Сургалт хүмүүжлийн сургуулийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ ХЗДХЯ-аас эрх шилжүүлсэн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх: 405, 409, 413, 433, 457 дугаар хаалттай хорих ангийн их засвар, Төр хур амралт нөхөн сэргээх сувиллын их засвар, 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн нярай хүүхэдтэй эмэгтэй хоригдлын байрны их засвар, ШШГЕГ-ын хуяглан хүргэлттэй тээврийн хэрэгсэл /орон нутаг/* | 2024 он | -2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлсэн байх;<br>- Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд, олон нийтийн саналыг авч, холбогдох арга хэмжээг авсан байх;<br>- Иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлсэн байх; | Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газар |
| | | 2.3. Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, харьяалах алба, газар, хэлтэс, анги, байгууллагуудад зөвлөмж, чиглэл хүргүүлэх, үр дүнг тооцох; | 2024 он | -Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж, тайлагнах;<br>-Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших;<br>-Иргэд, олон нийтээс байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлсэн байх; | Хяналт шалгалт, аюулгүй байдлын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Захиргааны удирдлагын газрын Хууль тогтоомж, төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс |
| 3 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | 3.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах. | 2024 он | -Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авсан байх; | Хорих ял эдлүүлэх алба, Шийдвэр гүйцэтгэх алба, Төв архив |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | -Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлсэн байх;<br>-Хэрэгжилтийг тайлагнасан байх; | |
| | | 3.2. ШШГБ-аас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмжийн талаар хөндлөнгийн байгууллагаар “Хэрэглэгчийн үнэлгээ” хийлгэх. | 2024 он | -ШШГЕГ болон анги, байгууллагаар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдээс судалгааг авч, нэгтгэх, дүн шинжилгээ хийх;<br>-Судалгааны үр дүнд цаашид хэрэгжүүлэх санал, зөвлөмж гаргах;<br>-ШШГБ-ын хэмжээнд үйлчлүүлж буй хэрэглэгч, иргэд, олон нийтийн хандлага, түүнд нөлөөлж буй эерэг, сөрөг хүчин зүйл, цаашид анхаарах асуудлыг тодорхойлж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх; | Хяналт шалгалт, аюулгүй байдлын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс |
| | | 3.3. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр дотоодын хяналт шалгалтыг чанартай зохион байгуулж, хяналт шалгалтын үр дүнд илэрсэн зөрчил дутагдлыг давтан гаргуулахгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор үүрэг, чиглэл өгөх; | 2024 он | -Дотоод хяналт шалгалт сайжирч, анги, байгууллагын үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдсан байх;<br>-Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших;<br>- Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан эрсдэлийг тодорхойлсон байх;<br>-Эрсдэлийг арилгах арга хэмжээнд дотоод хяналтын | Хяналт шалгалт, аюулгүй байдлын газрын Хяналт шалгалтын хэлтэс |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | үйл ажиллагааг зохион байгуулсан байх; | |
| | | 3.4 Анги, байгууллага нь дотооддоо хяналт шалгалтын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх, түүний үр дүнд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах байдлаар хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах; | 2024 он | -Хяналт шалгалтын үйл ажиллагаа тогтмолжиж, бэхэжсэн байх;<br>-Анги, байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангасан байх; | Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгж |
| | | 3.5. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж;<br>-Мөрдөгчийн мэдэгдэл,<br>-Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд тодорхой арга хэмжээ зохион байгуулах; | 2024 он | -Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх<br>-АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн хувийг Хяналт шалгалт, аюулгүй байдлын газарт ирүүлэх; | ШШГЕГ-ын алба, газар, хэлтэс, харьяа анги, байгууллага |
| 4 | Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх “Шүүх, хууль хяналтын байгууллага дахь авлигын талаарх төсөөллийн судалгааг сайжруулах чиглэлээрх ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх | 4.1. Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах. | 2024 он | -Албан хаагчдад урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, мэдээлэл зохион байгуулсан байх;<br>-Сургалтын чанар, үр дүнг сайжруулсан байх;<br>-Шинэлэг хэлбэрээр нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>-АТГ-тай хамтран сургагч багш бэлтгэх;<br>-Сургагч багшаар ажиллах албан хаагчдад зохих нэмэгдлийг шийдвэрлэх; | Соён гэгээрүүлэх, сургалт, судалгааны хэлтэс |
| | | 4.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэд нээлттэй утсыг тогтмол ажиллуулж, үр дүнг сайжруулах, үйл ажиллагааны шат дамжлагыг бууруулах, шуурхай байдлыг хангах; | 2024 он | -Нээлттэй утасны хэвийн ажиллагааг хангасан байх<br>-Байгууллагын үйлчилгээ иргэд, олон нийтэд шуурхай хүрсэн байх;<br>-Үр дүнг нэгтгэн, цаашид авах арга хэмжээг тодорхойлж, олон нийтэд мэдээлсэн байх; | Захиргааны удирдлагын газар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 4.3. Шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөхийг хориглосон сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах. | 2024 он | -Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хуулийн хүрээнд явагдаж, шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байх;<br>-Иргэд, олон нийтийн мэдлэг дээшилсэн байх; | Шийдвэр гүйцэтгэх алба, Хорихоос төрлийн ял эдлүүлэх алба, Аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс |
| | | 4.4. Албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн хууль бус үйл ажиллагаа, авлигатай холбоотой аливаа асуудлыг АТГ-т мэдэгдэх, мэдээллийн болон мэдээлэгчийн нууцлалыг хамгаалах чиглэлээр зохион байгуулалт хийх. | 2024 он | -Албан хаагчийн хууль бус үйл ажиллагаа, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой мэдээллийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх;<br>-Мэдээлэгчийн нууцлалыг хангах, холбогдох байгууллагад шилжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангасан байх; | Хяналт шалгалт, аюулгүй байдлын газрын Хяналт шалгалтын хэлтэс,<br>Хорих анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгж |

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР